



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА, ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

Хуульд заасан шаардлага: Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5, 11.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Үүнд:

11.4.Байнгын хорооноос санал болгох нэр дэвшигч хувийн хэвшлийг төлөөлсөн байж болно.

11.5.Хорооны гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй:

11.5.1.төрийн улс төрийн албан хаагч;

11.5.2.улс төрийн намын удирдах албан тушаалтан;

11.5.3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;

11.5.4.санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдэд ажиллаж байгаа этгээд;

11.5.5.санхүүгийн үйлчилгээ явуулж байгаа хуулийн этгээдийн энгийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч.

11.6.Хорооны дарга, гишүүн нь эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй, Монгол Улсын иргэн байна.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	<p>Эцэг/эхийн нэр: Түндэв Ургийн овог: Бүргээ Нэр: Жамбаажамц Хүйс: Эрэгтэй Төрсөн он: 1982.06.26 Төрсөн газар: Баянхонгор аймаг, Баянхонгор сум Иргэний харьяалал: Монгол Одоо оршин суугаа аймаг /нийслэл, сум/ дүүрэг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо, 19 дүгээр хороолол, 101-07 тоот <i>/мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/</i></p>
-----	--

1.2	<p>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал Санхүүгийн зохицуулах хорооны дарга</p>
1.3	<p>Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Үгүй бол Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэхийг тодорхой бичих/</i> Тийм.</p>
1.4	<p>Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. <i>/сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ/</i></p> <ul style="list-style-type: none"> • Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Бизнесийн удирдлагын магистр; • Монгол Улсын Их Сургууль, Хууль зүйн сургууль, Олон улсын эрх зүйч мэргэжлээр бакалавр.
1.5	<p>Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг Байхгүй.</p>
1.6	<p>Эрүүл мэнд Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэхийг тодорхойлсон нотлох баримтыг жагсааж, хавсаргана. Эрүүл.</p>
1.7	<p>Эрхэлсэн ажил Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр эзэмшсэн мэргэжлээрээ таваас доошгүй жил ажилласан туршлагатай, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвартай болохыг нотлох баримтыг хавсаргана. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч <i>/эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</i></p> <p><u>Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл:</u></p> <ul style="list-style-type: none"> • 2016 оны 8 дугаар сараас одоог хүртэл Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга; • 2015-2016 онд Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газрын орлогч дарга; • 2014-2015 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга; • 2013-2014 онд Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгийн зах зээлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга; • 2011-2013 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах хянан шалгагч; • 2009-2011 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын хянан шалгагч; • 2007-2009 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын мэргэжилтэн;

	<ul style="list-style-type: none"> • 2006-2007 онд Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газрын мэргэжилтэн. <p><u>Удирдах албан тушаалтны мэдээлэл:</u></p> <p>1. Д.Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны дарга (2019-), Утас: 99110178, Цахим шуудан: Bayarsaikhan@frc.mn</p>
1.8	<p>Ашиг сонирхлын зөрчил</p> <p>Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшдэг, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг эсэх, Банк бус санхүүгийн байгууллага, банкны хувьцаа эзэмшдэг эсэхийг бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар хувьцаа, аж ахуйн үйл ажиллагааг ямар хугацаанд эзэмшиж, эрхэлж байгаа, эсхүл эзэмшиж, эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</p> <p>Үгүй.</p>
1.9	<p>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал</p> <p>Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.10	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Сүүлийн таван жил ямар мэргэжлийн холбоо, байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан, гишүүнчлэлийн талаар бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаал, чиг үүрэг гүйцэтгэж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</p> <p>Эрх зүй эдийн засгийн ухааны холбооны үүсгэн байгуулагч бөгөөд удирдах зөвлөлийн гишүүн 2015 оноос хойш;</p> <p>Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч; 2006 оноос хойш гишүүн байгаа бөгөөд төрийн албанд томилогдоод эрхээ түр түдгэлзүүлсэн байгаа болно.</p>
1.11	<p>Мэргэжлийн ёс зүйн талаар</p> <p>Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж бсайдсан эсэх. /тийм эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>

1.12 Хэрэв доор дурдсан мэдээлэл нэр дэвшигчид байгаа бол

- Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.

- Үнэт цаасны эрх зүй (гарын авлага), Улаанбаатар хот, 2013 он – Хамтран зохиогч
- Монгол Улсын Компанийн засаглалын үндэсний тайлан, Улаанбаатар хот, 2013 он
- Монгол Улсын Компанийн засаглалын үндэсний тайлан, Улаанбаатар хот, 2014 он
- Хувьцаа эзэмшигчийн эрх (гарын авлага), Улаанбаатар хот, 2017 он – Хамтран зохиогч
- Төрийн өмчит компаниудад хийсэн компанийн засаглалын үнэлгээний тайлан, Улаанбаатар хот, 2019 он
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулалтын үнэлгээний тайлан, Улаанбаатар хот, 2020 он

-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.

Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг болон УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэх ажлын дэд хэсгийн гишүүнээр ажилласан хуулиуд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, 2010 он
- Компанийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), 2011 он
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, 2011 он
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), 2013 он
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, 2013 он
- Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, 2017 он
- Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2021 он
- Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, 2022 он
- Зөвшөөрлийн тухай хууль, 2022 он
- Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, 2022 он
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль, 2023 он
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2024 он
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2024

Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулж, батлахад оролцсон дүрэм, журам, заавар:

- Үнэт цаасны бүртгэлийн журам
- Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам
- Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчдийн үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журам
- Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх тухай журам
- Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны зохицуулалтын журам
- Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам
- Хөрөнгө оруулалтын менежментийн тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагаа эрхлэх тухай журам
- Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам
- Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам
- Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журам
- Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам
- Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам
- Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага
- Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам
- Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам
- Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам
- Сэндбокс зохицуулалтын орчны журам
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам зэрэг санхүүгийн зохицуулалтын

дүрэм, журам, заавар, аргачлалуудыг боловсруулах болон батлах ажиллагаанд оролцсон.

Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулахад оролцсон эмхэтгэл, тайлан:

- Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж, дүрэм, журмын эмхэтгэл, Боть 1, Улаанбаатар хот, 2014 он
- Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж, дүрэм, журмын эмхэтгэл, Боть 2, Улаанбаатар хот, 2014 он
- Санхүүгийн зохицуулах хорооны 2008-2018 он, 2020-2023 оны үйл ажиллагааны тайлангууд
- Үнэт цаасны зах зээлийн захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл, Улаанбаатар хот, 2021 он
- Даатгалын зах зээлийн захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл, Улаанбаатар хот, 2021 он
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын дүрэм, журмын эмхэтгэл, Улаанбаатар хот, 2021 он

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

- Компанийн засаглал түүний ач холбогдлын талаар хэлэлцүүлэг, Санхүүгийн зохицуулах хорооны байр, 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

Товч утга: Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгох, санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлээр бид бүхэн бодлогын томоохон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үр дүнд нь хувьцаат компаниудын засаглалын чанарыг сайжруулах замаар урт болон дунд хугацаанд зах зээлийн үнэлгээ, үнэ цэнийг нэмэгдүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, шийдвэр гаргах ажиллагаанд тэдгээрийн оролцоог хангах боломжийг сайжруулсаар байна. Төрийн байгууллага мэргэжлийн судлаачидтай хамтран зохицуулалтын салбаруудад компанийн засаглалыг хэрэгжүүлэхэд тулгарч буй нөхцөл байдал болон цаашдын чиг хандлага зэргийг хослуулан үнэт цаасны зах зээлд оролцогчдод мэдээлэл хүргэж байгаа нь нэгдсэн ойлголтыг бий болгоход чухал ач холбогдолтой юм.

<https://www.m21.mn/a/913>

- Нийтэд санал болгон гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны цан цохих ёслол, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн байр, 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр

Товч утга: Хөгжиж буй орнуудын үндэсний томоохон компаниуд нь тухайн орныхоо хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, олон нийтийн хувьцаат компани байдаг. Энэ жишгээр манай улсын томоохон компаниуд болон тэдгээрийн охин компаниуд олон нийтийн болох хандлага сүүлийн хоёр жил эрс нэмэгдсэн. Санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, хөрөнгийн зах зээлийг тэлэх, үнэт цаас гаргагчдад тохирсон шаардлагуудыг тодорхой болгох, түүнчлэн УИХ-аас баталсан бодлогын томоохон арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн. Энэ ажлуудын хүрээнд Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах компаниудын оролцоо нэмэгдсэн.

<https://ikon.mn/n/2mtw>

- IPO MONGOLIA 2022-Хүртээмжтэй хөрөнгийн зах зээл, 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

Товч утга: Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг нэмэгдүүлэх

<https://www.ubchamber.mn/a/303>

- Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны цан цохих ёслол, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн байр, 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр

Товч утга: Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинж чанар, нэр төрлийн хувьд нэлээн онцлог санхүүгийн бүтээгдэхүүн гарч байна. Энэ бүтээгдэхүүнийг Монголын Хөрөнгийн биржээр олон нийтэд санал болгож буй юм. Энэхүү шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүний онцлог нь ирээдүйд мөнгөн урсгал бий болгох боломжтой чанартай активууд дээр суурилж гаргах боломжтой. Тухайлбал, түрээсийн аж ахуй нэгжүүд ирээдүйд орж ирэх тогтмол орлогоороо суурилж энэ төрлийн бүтээгдэхүүн гаргах бололцоотой. Мөн банк, ББСБ-ууд өөрийн олгосон чанартай зээлийн багцан дээр үндэслэн энэ бүтээгдэхүүнийг гаргах боломжтойгоороо онцлог. Өөрөөр хэлбэл ирээдүйд чанартай мөнгөн урсгал бий болгох боломжтой. Монгол Улсад 2010 онд Үнэт цаасны хуулийг баталж энэ төрлийн эрх зүйн харилцааг албан ёсоор бий болгосон. Сүүлийн хоёр жилийн хугацаанд ББСБ-ууд өөрийн гаргасан зээлүүддээ мэргэжлийн байгууллагууд хяналтын дор олон нийтэд зарах болон зах зээлд гаргаж байна. Монголд түрээсийн ААН-үүд олон бий. Тэд түрээсийн орлогоороо баталгаажуулж, үнэт цаасны бүтээгдэхүүн гаргах бүрэн боломжтой бөгөөд зөвхөн Хөрөнгийн биржээр гаргах шаардлагагүй ба нээлттэй, хаалттай гаргаж болохоороо онцлог юм.

<https://gogo.mn/r/3n7e2>

- Холбоотой хамтран ажиллах гэрээ, Санхүүгийн зохицуулах хорооны байр, 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр

Товч утга: Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс санхүүгийн зах зээлээ хөгжүүлэх, мэргэжлийн оролцогчдоо чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор мэргэжлийн холбоодтой байнга хамтран ажилладаг бөгөөд цаашдаа ч хамтын ажиллагааны хүрээг улам бүр тэлэх зорилго тавин ажиллаж байна. Үүний нэг бодит жишээ нь өнөөдрийн энэ үйл явдал. Тодруулж хэлбэл, Алт арилжаалагчдын холбоо, Монголын уран дархны “Түмэн эрдэнэс” холбоо, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Үнэт эдлэлийн холбоо зэрэг үнэт металлын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй холбоод нэгдэж байгуулсан Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн үндэсний холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулж байгаа нь салбарын хөгжилд дэвшил авчирна гэдэгт итгэлтэй байна. Хамтдаа салбарын бодлого стратегиа боловсруулах, зохицуулалтын зохистой орчин бүрдүүлэх, мэргэжлийн оролцогчдынхоо эрх ашгийг хамгаалах, чадавхжуулах гээд хийж хэрэгжүүлэх олон ажил биднийг хүлээж байна. Та бүгдийн хувьд ч Хороотой хамтран ажилласнаар санхүүгийн салбарын бусад холбоодтой хамтдаа хөгжих, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийн талаар мэдээлэл авах, сургалтын нэгдсэн стандарт, ижил үнэлгээтэй болох орчин бүрдэнэ. Хорооны зүгээс ч бүх талаараа дэмжиж, хамтарч ажиллах болно.

<https://news.mn/r/2352809/>

- Мэргэжлийн зарим холбоотой сургалтын чиглэлээр хамтран ажиллах гэрээ, Санхүүгийн зохицуулах хорооны байр, 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр

Товч утга: Санхүүгийн зохицуулах хороо мэргэжлийн холбоодтой нягт хамтран ажиллаж байна. Цаашдаа ч санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, мэргэжлийн оролцогчдоо чадавхжуулах, мэргэшүүлэх хүрээнд хамтын ажиллагаагаа улам бүр өргөжүүлж тэлнэ. Үүний нэг илрэл нь энэ удаагийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж буй үйл явдал. Өмнө нь мэргэжлийн холбоодыг Хорооны холбогдох газар, нэгж нь хариуцдаг байсан бол ажлын албаны бүтцэд энэ жил Санхүүгийн боловсрол, сургалтын албыг шинээр байгуулсан. Ингэснээр мэргэжлийн байгууллагууд нэгдэх, хамтдаа хөгжих, сургалтын нэгдсэн нэг стандарт, нэг үнэлгээтэй болох боломж бүрдэнэ гэж үзэж байна. Цаашдаа ч хамтран хийх ажлууд бидэнд их бий. Иймээс аливаа асуудлыг хамтдаа хэлэлцэж, шийдвэрлэж ажиллах болно. Хороо бүхий л талаараа дэмжиж, хамтарч ажиллана.

<https://www.inews.mn/a/16219>

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

- Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, “Ярилцъя” үйл явдал, тойм тайлбар зочин, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр

Товч утга: Олон нийтэд үнэт цаас гаргаж, санал болгох, нээлттэй хувьцаат компани болох арга зам, давуу тал, бодлогын дэмжлэг

<https://www.youtube.com/embed/8RLnzzsExrE>

- www.lkon.mn, 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр

Товч утга: Үл хөдлөх хөрөнгө зуучлалын болон үнэт эдлэлийн салбар зохицуулалттай болсноор гарч буй үр дүн, тоон мэдээлэл, нөхцөл байдал, цаашдын чиг хандлага

<https://ikon.mn/n/2po4>

- Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

Товч утга: Хөрөнгийн зах зээлийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, хөрөнгө оруулагчид мэдлэг олгох

<https://www.youtube.com/embed/JalryJvc5tw>

- Монголиан экономи сэтгүүл, 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдөр

Товч утга: Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэх хүрээнд хийгдэж буй ажил, зах зээлийн хөгжүүлэхэд чиглэж буй арга хэмжээ

- www.unuudur.mn, 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр

Товч утга: Олон улсын мөнгө угаахтай тэмцэх байгууллага ФАТФ-аас Монгол Улсад өгсөн зөвлөмж, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

<https://www.unuudur.mn/a/230499>

- Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, Санхүүгийн зах зээлийн цаг нэвтрүүлэг, 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр

Товч утга: Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны тухай

- Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр

Товч утга: Олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах нь маш чухал. Хувьцаат компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын ил тод, нээлттэй байдлыг

олон улсын сайн жишигт хүргэх нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх, компанийн зах зээлийн үнэлгээ бодитоор тогтох суурь нөхцөлүүдийг бүрдүүлнэ.

<https://www.mnb.mn/i/221877>

- www.eguur.mn, 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдөр

Товч утга: “Эрдэнэс тавантолгой” ХК-аас олгох ногдол ашгийн талаар

<https://eguur.mn/129301/>

- Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, “Цагийн хүрд”, 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдөр

Товч утга: Цар тахалтай холбогдуулан зээлийн үндсэн зээл, хүүг хойшлуулсан тухай

<https://www.youtube.com/embed/LuAc6zIWKYs>

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1 Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ.
/500-1000 үгэнд багтаана/.

Миний бие Монгол улсын санхүүгийн зах зээлийн хяналт зохицуулалтын нэгдсэн байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороонд анх байгуулагдсан үеэс нь Мэргэжилтэнгээр ажлын гараагаа эхэлж байснаас хойш өдгөө 19 дэх жилдээ тасралтгүй төрийн албанд ажиллаж байна. Энэ хугацаандаа байгууллагатайгаа хамт өсч, хөгжиж суралцсаар ирсэн бөгөөд үнэт цаасны зах зээлийн болон бусад санхүүгийн салбарын хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох ажилд идэвхтэй, гар бие оролцож ажилласан. Хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн орнуудын санхүүгийн зах зээлийн зохицуулагч байгууллагууд, томоохон хөрөнгийн биржүүд болон хөрөнгө оруулалтын сангуудад урт, дунд хугацааны мэргэшүүлэх хөтөлбөрүүдэд удаа дараа хамрагдаж, мөн салбар тус бүрийн хяналт зохицуулагчдыг нэгтгэсэн олон улсын байгууллага, нийгэмлэгүүдтэй хамтарч ажиллаж, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, туршлага солилцсоноор санхүүгийн зах зээлийн зохицуулагч төрийн институтцийн онцлог, чиг үүрэг, эрх хэмжээ, хандлага, соёл гээд олон зүйлүүдийг газар дээр нь танилцаж, мэдрэн, практик туршлагыг тодорхой хэмжээнд цуглуулж ажилласан хүний хувьд цаашид өнөөгийн санхүүгийн зах зээлийн ололт амжилт, өсөлтийг хадгалах, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг олон улсын жишигт нийцүүлэн үргэлжлүүлэн хөгжүүлэх, үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах илүү ухаалаг санхүүгийн зах зээлийн орчинг бүрдүүлэх зорилгоор дараах ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай гэж үзэн, уг албан тушаалд нэрээ дэвшүүлэв.

Санхүүгийн зарим үйл ажиллагааг зохицуулж буй одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 2002 онд батлагдаж, нэмэлт, өөрчлөлт 12 удаа, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль 2011 онд батлагдаж, нэмэлт, өөрчлөлт 4 удаа, Даатгалын тухай хууль

2004 онд батлагдсан, нэмэлт, өөрчлөлт 17 удааг тус тус орсон. Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох, салбарын өсөлтийг нэмэгдүүлэх хүрээнд эдгээр хуулиудыг шинэчлэх зайлшгүй шаардлага практикт бий болсон гэж үзэж болохоор байна. Мөн технологид суурилсан санхүүгийн шинэ үйлчилгээ бий болж, салбарын харилцагч, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэн, зах зээлд тэлэлт явагдаж байгаатай холбогдуулан хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалсан, хөрөнгө оруулалтыг татах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн, салбарын хөгжлийн чиг хандлагыг олон улсын жишигт нийцүүлсэн эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна. Иймээс салбар тус бүрийн эрх зүйн орчныг шинэчлэлийг хийж, хөрөнгө оруулагч, харилцагч, үйлчлүүлэгчийн эрх ашиг хамгаалагдсан, тогтвортой, зардал бага, үр ашигтай санхүүжилтийг тогтолцоог үргэлжлүүлэн хөгжүүлэх, санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад таатай, итгэл хүлээсэн санхүүгийн зах зээлийн тогтолцоог бий болгох бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Тухайлбал, дотоодын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгийн зах зээлтэй холбох, хөрөнгө оруулагчдад таниулан сурталчлах, хөрөнгийн зах зээлд оролцох идэвх, сонирхлыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн эрчимжүүлэх шаардлагатай. Зах зээлийн эрх зүйн орчин олон улсын жишигт нийцсэн таатай, тогтвортой байхаас гадна шаардлага хангахуйц бүтээгдэхүүн, үйлчилгээтэй, хөрвөх чадвар сайтай хөрөнгийн зах зээлтэй улс оронд дотоод, гадаад хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулах сонирхолтой байдаг. Хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, зохицуулалттай зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэх хүрээнд УИХ-аас Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2024 онд баталснаар хувьцааны хамтын санхүүжилт, хадгаламжийн сертификат, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ зэрэг санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Иймд эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой нарийвчилсан процессыг зохицуулах журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, батлуулах арга хэмжээг төлөвлөж байхаас гадна томоохон аж ахуйн нэгжийн үнэт цаасыг хөрөнгийн зах зээлд нээлттэй арилжаалах боломжийг бодлогоор дэмжих ажлыг гүнзгийрүүлнэ. Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хамтын хөрөнгө оруулалтын сан, даатгалын компани, банк, банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны компаниудын идэвхийг нэмэгдүүлж, урт хугацааны санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох тогтолцоог бэхжүүлэх, ногоон буюу байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, зах зээлийг бий болгох хүрээнд хөрөнгө оруулалтыг татах бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгоно. Үүнээс гадна Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлж, хөрөнгийн зах зээлийг төрөлжүүлэн үл хөдлөх хөрөнгийг хөрөнгө оруулагчдад илүү хүртээмжтэй, эрсдэл багатай байдлаар санал болгох тогтолцоог бүрдүүлэхээр ажиллана.

Мөн Даатгалын зах зээлийн салбарын өнөөгийн нөхцөл байдлыг бүтэц, төвлөрлийн хувьд дүгнэвэл ердийн даатгал давамгайлсан буюу нийт хураамжийн орлогын 99.0 хувийг ердийн даатгалын хураамж эзэлж байгаа эзэлж байна. Харин даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д даатгалын хураамжийн орлогын эзлэх хувь 0.58 байгаа нь дэлхийн дунджаас даруй 11-12 дахин бага, нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ буюу даатгалын нягтрал 113,377.4 төгрөг байгаа нь дэлхийн дунджаас даруй 20-30 дахин бага байна. Эдгээрээс

харахад даатгалын салбарын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсын даатгалын зах зээлийн чиг хандлага, хөгжилд гарч буй өөрчлөлт, шинэчлэлтэй уялдуулан техник, технологийн хувьсгалд нийцүүлж хөгжүүлэх, олон тулгуурт салбарыг бий болгох, эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам боловсронгуй болгох арга хэмжээнүүдийг төлөвлөж ажиллана.

Хадгаламж, зээлийн хоршооны зах зээлийн найдвартай байдал болон хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалахын тулд дэлхийн улс орнууд хамгаалалтын 2-3 давхарга бүхий тогтолцоог бий болгох жишиг тогтсон байна. Олон улсын чиг хандлагад хадгаламж хамгаалалттай холбоотой асуудалд хадгаламж, зээлийн хоршоодыг банкны салбарын нэгэн адил зохицуулахад чиглэж байна. Хадгаламж хамгаалах тогтолцоог нэвтрүүлснээр зах зээлд орох мөнгөний урсгал нэмэгдэх, гишүүдийн тоо өсөх, иргэдийн хадгаламж, зээлийн хоршоонд, цаашлаад зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэргээр санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд эерэг нөлөөтэй тул санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажил тэргүүн ээлжид тавигдаж байна. Манай орны хувьд хадгаламж, зээлийн хоршоод хамгаалалтын нэгдүгээр давхаргын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 3 давхаргат хамгаалалтын тогтолцоог нэвтрүүлэх, салбарын нэгдсэн дэд бүтцийг бий болгох зохицуулалтаас гадна засаглал, санхүүгийн тайлагнал, цахим шилжилт, ашгийн төлөө бус хуулийн этгээд байх нарийвчилсан зохицуулалтуудыг нэвтрүүлснээр зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг гүйцэтгэх шаардлагатай байх тул уг хүрээнд хадгаламж, зээлийн хоршооны салбарыг хөгжүүлэх бодлого барьж, үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Банк бус санхүүгийн салбарын хувьд сүүлийн жилүүдэд технологид суурилсан санхүүгийн шинэ үйлчилгээ бий болж, салбарын харилцагч, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэхийн хэрээр үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалсан, салбарын оролцогчдыг чадавхжуулж, санхүү, төлбөрийн чадварыг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцсэн төрөлжсөн мэргэшсэн институт болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд учрах санхүүгийн ачааллыг бууруулах зорилгоор тус зохицуулалтын орчинг олон улсын жишигт нийцүүлэх хэрэгцээ бий болсон. Иймд Банк бус санхүүгийн байгууллагыг эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн онцлог, эрсдэлийг харгалзан үйлчилгээгээр нь төрөлжүүлж, олон улсын жишигт нийцүүлэн “Зээлийн банк бус санхүүгийн байгууллага”, “Хөрөнгө удирдлагын банк бус санхүүгийн байгууллага”, “Факторинг”, “Валют арилжаа” гэж ангилан шалгуур, шаардлага, зохицуулалтыг ялгавартай тогтоох эрх зүйн орчны шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

Дээр дурдсан санхүүгийн тулгуур салбаруудаас гадна ФАТФ-аас тавьсан шаардлагыг биелүүлэх хүрээнд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч болон Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт металл, үнэт эдлэлийн зохицуулалтын салбарын зохицуулалт болон хяналтыг Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэг, бүрэн эрхэд хамааруулсан байдаг. Зохицуулалтад хамаарах эдгээр санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн үйл ажиллагааны хуулийг бүрэн хэрэгжүүлэх, зах зээлийн эрх зүйн орчинг сайжруулах, залилах болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг зохистой, хууль тогтоомжид нийцүүлэн явуулах, хөрөнгө оруулагч, харилцагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах зэрэг шаардлагыг харгалзан хяналт зохицуулалтыг эрсдэлд суурилсан тогтолцоонд бүрэн шилжүүлэх буюу бодит цагийн горимоор технологийн дэвшлийг ашиглан хэрэгжүүлэхэд бодлого, үйл ажиллагааг чиглүүлнэ.

	<p>Түүнчлэн Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас олон улсын хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мөрдөх техникийн 40 зөвлөмжийг гаргасан ба уг зөвлөмжийн үнэлгээг сайжруулах чиглэлээр шуурхай арга хэмжээ авсны үр дүнд 2024 оны байдлаар ФАТФ-ын зөвлөмжийг бүрэн хангасан дэлхийн 5 дахь, ази, номхон далайн бүс нутгийн хэмжээнд анхны орон болсон. Монгол Улсын дараагийн шатны харилцан үнэлгээ 2027-2028 оны хооронд хийгдэхээр төлөвлөгдсөнөөс гадна харилцан үнэлгээг ФАТФ-ын шинэчилсэн аргачлалын дагуу үнэлэх тул тус харилцан үнэлгээг амжилттай хамгаалах бэлтгэл ажлыг хангахад зорьж ажиллана.</p>
--	--

Хавсралт:

Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:

- 1.Төрийн албан хаагчийн анкет;
- 2.Эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр;
- 3.Иргэний үнэмлэхийн хуулбар;
- 4.Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- 5.Боловсролын зэргийн дипломын хуулбар;
- 6.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;
- 7.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэгт заасан чиглэлээр мэргэшсэн, тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай түвшний мэдлэг, чадвар, туршлага, ёс зүйтэй гэдгийг нотлон харуулсан 10-аас доошгүй тодорхой үйл ажиллагааны талаарх баримт;
- 8.Энэхүү загварт заасан баримт бичиг;
- 9.Холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Түндэв

Өөрийн нэр: Жамбаажамц

Гарын үсэг:

Он, сар, өдөр: